

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс, дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5			
Нэг. МУ-ын хууль							
1	1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан 4 бүлэг, 12 зорилтын хүрээнд гэр бүлийн хөгжил хамгааллын 113 удаагийн сургалт, үйл ажиллагааг 27455 иргэн хамруулан зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх 4 удаагийн сургалт, арга хэмжээнд 262 гишүүн хамруулсан. “Би хариуцлагатай аав, ээж” аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг судлах талаар гэр бүлд зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө мэдээ, мэдээллийг агуулсан сэтгүүлийг 50 эцэг, эхэд тараахын зэрэгцээ 5 удаагийн сургалтад 358 иргэнийг хамруулсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхчүүдийн дунд ЭССЭ бичлэгийн уралдаан зохион байгуулж дүгнэсэн. Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр 6 арга хэмжээ, 25 удаагийн сургалтад 2492 иргэнийг хамруулсан.	90%	100	
	2	Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хан-Уул дүүргийн 24 хорооны хамтарсан багийн 135 гишүүн хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 24 хорооны хамтарсан багийн гишүүдэд ажлын	90%	100		

			байранд мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 4 удаагийн арга хэмжээнд хамтарсан багийн давхардсан тоогоор нийт 262 гишүүнийг хамруулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хороодын хамтарсан багийн үйл ажиллагааны бичиг хэргийн зардалд 300,000 төгрөгийн дэмжлэг үзүүлснээс гадна Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсээс хамтарсан багт шатахуун, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 100 өрхөд хүнсний эрхийн бичиг, НАМС программд шивж оруулсан кейсийн зардлыг хорооны нийгмийн ажилтанд тус тус олгосон.			
3		19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх хүчирхийллийн хохирогчид нэг цэгийн үйлчилгээний төвийг Хан-Уул дүүргийн Засаг даргын санаачилгаар 2017 оны 06 дугаар сарын 18-ны өдөр “Аз жаргалтай гэр бүл” хөтөлбөрөөс санхүүжүүлэн “Түр хамгаалах байр”-ны зориулалттай байгуулсан. Уг барилга нь 1956 онд ашиглалтад орсон бөгөөд ашиглалтын хугацаа дууссан тул буулгаж, шинээр барихад шаардагдах 500.0 сая төгрөгийг 2022 оны орон нутгийн төсөвт тусгасан. 2022 оны 2 дугаар сард тендерийн ажил зарлагдсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан тус ажил хэрэгжээгүй тул төсвийг шинэчлэн 800.0 сая төгрөгийг 2023 оны төсөвт тусгах санал хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар 55 хүүхэд, 1 насанд хүрэгч нийт 56 иргэнд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах 68,8 сая төгрөгийг Нийслэлийн төсвөөс зарцуулсан.	90%	100	
4		19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5 дахь зорилтод гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг төлөвлөн тусгаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Тус ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах 10.0 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусгасан. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд архи, согтууруулах ундааны	80%	70	

		бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	хор хөнөөлийг олон нийтэд таниулах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангахад чиглэсэн "Архигүй орчин" дэд хөтөлбөрийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2021 оны А/122, А/134 дүгээр захирамжаар, хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ болон шаардагдах 33,159,000 төгрөгийн төсвийг тус тус батлуулж, хэрэгжүүлсэн.			
5		19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийн 2022 оны төсөв 70.0 сая төгрөг батлагдсанаас 69.0 сая төгрөгийн зарцуулалттай, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 36.9 сая батлагдсанаас 36.6 сая төгрөгийн зарцуулалттай байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг шинээр барих болон хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардал нийт 910.0 сая төгрөгийн төсвийг 2023 оны төсөвт тусгах санал хүргүүлсэн. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, А/27 дугаар тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага мэдээлэлд хариу үйлчилгээ үзүүлж ажилладаг хороодын хамтарсан багт нийт 8,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, иргэдийг хорт буруу зуршлаас ангижруулах чиглэлээр хэрэгжүүлж буй "Урам" төсөлд 3,0 сая төгрөгийн төсвийг тус тус зарцуулсан.	80%	70	
6		19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж,	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2022 онд нийт 56 иргэн /насанд хүрэгч-1, хүүхэд-55/ үйлчлүүлсэн. Боловсролын үйлчилгээнд 8, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 23, эрүүл мэндийн	80%	70	

		тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	тусламж үйлчилгээнд 8 хүүхдийг хамруулсан. Нэг цэгийн үйлчилгээний төв, Хүүхэд тусламжийн 108 утсанд бүртгэгдсэн 733 дуудлагаас 2 хүүхдийг асрамж халамжийн газарт шилжүүлж, 54 хүүхдийг ар гэрт нь эргэн хүлээлгэн өгч, гэр бүлийн хүчирхийлэлтэй өрхүүдэд хамтарсан баг хяналт тавьж ажилласан. Хан-Уул дүүргийн нийт 24 хорооноос 13 хорооны байранд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ганцаарчилсан зөвлөгөө өгөх, уулзалт хийх өрөөгөөр хангагдсан. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд нэн шаардлагатай 70.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.			
7		19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Албан бус-Насан туршийн боловсролын төв хамтран 2022 оны 4 дүгээр сараас "Урам" төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, архины хамааралтай 90 иргэнийг сонгон авч, ганцаарчилсан ярилцлага, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Азийн сан, Тайваний Хүүхэд, гэр бүлийг дэмжих сан зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, хороодын хамтарсан гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 112 албан хаагчийг хамруулсан. Улаан загалмайн хорооноос хүүхэд, эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, энэ чиглэлээр ажиллах сайн дурын идэвхтнүүдийг сонгосон. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст бүртгэлтэй гэр бүлийн хүчирхийлэлтэй 100 өрхийн судалгаанд үндэслэн хорооны хамтарсан багтай хамт хяналт тавьж, иргэдийг архины хор уршгийг таниулах сургалт мэдээлэлд хамруулж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамруулсан.	80%	70	
8		19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон	Гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомж	90%	100	

			<p>нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)</p>	<p>сурталчлах сургалтад төрийн болон төрийн бус байгууллагын 420 ажилтан, алба хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 649 сурагч, 30 багш, нийгмийн ажилтан, их дээд сургууль, мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 280 оюутныг хамруулсан. Иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг мэдээлэл олгох, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх зорилготой 4 удаагийн сургалтад 200 гаруй иргэнийг хамруулсан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өрнүүлсэн “Хүүхэд хамгаалал-2022”, “Өөрөө үлгэрлэе”, “Хариуцлагаар үлгэрлэе.” “Хүндлэлээр хүмүүжье”, “Зөвийг зөвлөө”, “Цахим соёл” зэрэг аянд нэгдэж, иргэд, олон нийтэд арга хэмжээний зорилго, чиглэлийг сурталчилсан.</p> <ul style="list-style-type: none"> - “Хүүхэд гэр бүлд ээлтэй” дүүргийн хэмжээнд 5 байгууллагыг шалгаруулж, 6 байгууллагын материалыг дараагийн шатны шалгаруулалтад илгээснээс “Говь” ХХК нь Нийслэлийн Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллагаар шалгарсан. - “Шилдэг эцэг эхийн зөвлөл” шалгаруулах удирдамжийг 21 хороо, холбогдох газруудад хүргүүлэн дүүргийн нийт 9 ААН байгууллагын материалыг хүлээн авч шалгаруулан, 3 материалыг Нийслэлийн шалгаруулалтад илгээсэн. 			
	9		<p>25.2.. Тухайн орон нутгийн хүн амын тоо, эрүүгийн болон нийгмийн хэв журмын нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн байгууллагын бүтцэд цагдаагийн мэргэшсэн алба хаагчдаас бүрдсэн нэгжтэй байж болно.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд гэр бүл, хүүхэд, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан нэгжийг 2017 оны 01 дүгээр сарын Б/46, Б/47 дугаар тушаалаар байгуулж, Гэр бүл, хүүхэд, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 2, Гэр, бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн 2, Хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 2, Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 4 нийт 11 алба хаагч томилогдон ажиллаж байна.</p>	100%	100	
2	10	Төрийн албаны тухай	<p>55.3.. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл,</p>	<p>Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр</p>	90%	100	

		/Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 ажил тусгасан 90 хувь хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд нийт 25 төрлийн сургалтад 122, цахим болон цаг үеийн шинжтэй бусад сургалтуудад 300 гаруй албан хаагчийг тус тус хамруулсан. Дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран Засаг даргын Тамгын газрын 62 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулан эмчилгээ хийлгэх шаардлагатай 17 албан хаагчид өдрийн эмчилгээ хийлгэсэн. Мөн ХБНГУ-ын Денк фармын Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран "Эрдэс витамин хэрэглээ", "Ясны сийрэгжилтийн үзлэг оношилгоо"-нд 43 албан хаагчийг хамруулж, мэргэжлийн эмч холбогдох зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг харгалзан нийт 18 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд Засаг даргын Тамгын газрын дотоод журмын дагуу 33 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.			
3	11	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02	19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;	Хан-Уул дүүргийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг хуулийн хугацаанд гаргаж, тайланг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр цахим санд оруулсан. Засаг даргын Тамгын газрын нийт 160 албан хаагчдын 55 буюу 34,4 % эрэгтэй, 105 буюу 65,5% эмэгтэй, төрийн захиргааны 93 албан хаагчийн 18 буюу 19% эрэгтэй, 75 буюу 81% нь эмэгтэй, төрийн тусгай 6 албан хаагчийн 5 буюу 83% эрэгтэй, 17% нь эмэгтэй, улс төрийн 24 албан хаагчийн 13 буюу 54% эрэгтэй, 11 буюу 46%, төрийн үйлчилгээний 37 албан хаагчийн 19 буюу 51% эрэгтэй, 49% эмэгтэй эзэлж байна. Удирдах албан тушаалын 35 албан хаагчийн 18 буюу 51,4% эрэгтэй, 18 буюу 48,6% нь эмэгтэй байгаа нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж байна.	100%	100	
МУ-ын 3 хуулийн холбогдох 11 заалтын биелэлт					88.1%	89	

Хоёр. УИХ-ын байнгын хорооны тогтоол

4	12	<p align="center">“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ</p>	<p>3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.</p>	<p>Хан-Уул дүүргийн 24 хорооны хамтарсан багийн 135 гишүүн хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 2 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 24 хорооны хамтарсан багийн гишүүдэд ажлын байранд мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 4 удаагийн арга хэмжээнд хамтарсан багийн давхардсан тоогоор нийт 262 гишүүнийг хамруулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хороодын хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 300,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 100 өрхөд хүнсний эрхийн бичиг, НАМС программд шивж оруулсан кейсийн зардлыг хороодын нийгмийн ажилтнуудад олгосон. Гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, тогтоомж сурталчлах сургалтад төрийн болон төрийн бус байгууллагын 420 ажилтан, алба хаагч, ерөнхий боловсролын сургуулийн 649 сурагч, 30 багш, нийгмийн ажилтан, их дээд сургууль, мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 280 оюутныг хамруулсан. Иргэдэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг мэдээлэл олгох, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 4 удаагийн сургалт зохион байгуулж, 200 гаруй иргэнийг хамруулсан 2022 оны жилийн эцсийн байдлаар хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 4665 дуудлага мэдээлэл хүлээн авснаас хүүхдийн эрх зөрчигдсөн 616, гэр бүлийн хүчирхийлэл гэж тогтоогдсон 1754 дуудлага мэдээллээс 819 хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийж, нэг цэгийн үйлчилгээнд 49, төрөл садны хамгаалалтад 1021, асрамж халамжийн байгууллагад 57 хохирогчийг хүлээлгэн өгч,</p>	90%	100	
---	----	--	---	--	-----	-----	--

				эрсдэлийн дунд болон өндөр түвшин тогтоогдсон 36 иргэнийг хорооны хамтарсан багийн хяналтад шилжүүлсэн. "Хяналт" тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хараа хяналтгүй болон эцэг эхийн хараа хяналт сул, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх, эрсдэлтэй хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх 3 удаагийн "Илрүүлэлт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 9 хүүхдийг ар гэрт нь эргэн нэгтгэж, 2 хүүхдийг асрамж халамжийн төвд хүлээлгэн өгсөн. Өмнө оны мөн үетэй харьцуулахад хараа хяналтгүй хүүхдийн тоо 85 хувиар буурсан үзүүлэлттэй байна.			
УИХ-ын байнгын хорооны 1 тогтоолын холбогдох 1 заалтын биелэлт				90%	100		
Гурав. Ерөнхийлөгчийн зарлиг							
5	13	Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар: 159	Хоёр. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, 24 хороод, Засаг даргын дэргэдэх 29 хэлтэс, албад Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан. Мөн 2022-2023 оны хичээлийн жилийн нээлтээр Эзэн богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах арга хэмжээг зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн нийт 168 сургууль, цэцэрлэг Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залсан.	100%	100	
6	14	"Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58"	1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Төрийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд 15 байгууламж бүхий "Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төсөл хэрэгжиж байна. Энэ ажлын хүрээнд 2022 онд 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 3.47 га талбайд экспо талбай байгуулж, мод, зүлэг шинээр тарьж тохижуулсан. Дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул голын эрэг дагуу 2022-2031 онд 5 үе шаттайгаар 149 га талбайд хэрэгжих Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэн /Family Garden/ төсөл зураг төсөл боловсруулагдаж, мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх шатанд хэрэгжиж байна. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 3, 11, 15, 19, 21 дүгээр хорооны	90%	100	

			<p>5 байршилд ногоон байгууламж, амралтын талбай, тоглоомын талбай бүхий тохижилт, 2 дугаар хорооны 2 байршилд /2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд/ авто зогсоол, дугуйн зам, явган хүний зам, чийрэгжүүлэлтийн талбай, ногоон байгууламж бүхий тохижилт, 2, 16 дугаар хорооны 2 байршилд тоглоомын талбайн тохижилт, 1, 13, 21 дүгээр хорооны 5 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, 34, 52 дугаар сургуулийн гадна талбайд олон улсын стандартад нийцсэн 2 хөлбөмбөгийн талбай байгуулах ажил хэрэгжсэн. Дүүргийн 2021 оны 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 12, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хорооны 13 байршилд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай /гүйлтийн замтай/, чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмж суурилуулан тохижуулах ажлыг хэрэгжүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 2, 11, 12, 16, 17, 20 дугаар хорооны 7 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбайн тохижилтын ажлыг шинээр, 1 дүгээр хороо 14, 15 дугаар байрны тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөдөлгөөнийг сайжруулах зориулалт бүхий тусгай тоглоомыг суурилуулсан. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцохыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалан, идэвх оролцоог хангаж ажилласан. Тус ажлын хүрээнд 260361 ширхэг мод, бут, сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 267,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах, 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн.</p>			
--	--	--	---	--	--	--

	15		<p>1.7.Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутаг руу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2021 оны А/664 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газарт Айцын аманд 100 га, Айцын даваанд 10 га талбайг Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих зориулалтаар олгосон. “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай хамтарч Айцын амны 8 га талбайг хашаалж, ойжуулах, ойн зурвас байгуулах талбайн бэлтгэл ажлыг бүрэн хангасан. “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд Айцын аманд төр захиргааны 57, хувийн хэвшлийн 9 аж ахуйн нэгж байгууллагатай хамтарч нийт 7883 ширхэг мод, бут, сөөг тарьсан. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/293 дугаар захирамжаар ойжуулах, ойн зурвас байгуулах 100 га талбайн арчлалт, хамгаалалт, ашиглалтыг ойжуулалт, ойн зурвас байгуулах талбайн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-т хариуцуулан ажиллаж байна. Усалгаа, арчлалт, хамгаалалтад шаардагдах 108.8 сая төгрөгийн зардлыг шийдвэрлэж, усалгааны систем суурилуулах, худаг гаргах, харуул, хамгаалалтын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.</p>	90%	100	
	16		<p>1.8 Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж, ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх</p>	<p>Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд мод үржүүлгийн газар байгуулах, 14 дүгээр хороонд 100 га талбайг ойжуулах ажлын хүрээнд мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагуудтай хамтарч тус газруудад байгаль цаг уурын нөхцөлийг судлан тогтоох, хөрс, ус, уур амьсгалын судалгаанд үндэслэн үржүүлэх, тарих мод бутыг сонгох, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу 2022 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 14 дүгээр хороонд Айцын аманд 8 га талбайд 7883 ширхэг мод, бут, сөөг тарьж, ойжуулалтын ажлыг эхлүүлсэн. Төсвийн хөрөнгө оруулалт болон аж ахуйн нэгж, байгууллагын хамтарсан хөрөнгө оруулалтаар 1, 2, 3, 4, 8, 11, 12, 13, 15, 16, 17, 18, 19, 20, 21 дүгээр хорооны нийт 43 байршилд иргэд, олон нийтэд зориулсан тохижилт, ногоон байгууламж бүхий талбай,</p>	85%	70	

				тоглоомын талбай, спорт талбай /3х3 сагсан бөмбөгийн талбай хөлбөмбөгийн талбай/ байгуулах, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах тохижилт бүтээн байгуулалтын ажил хэрэгжсэн.			
	17		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/39 дүгээр захирамжаар иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчин бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор өрнөж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхтэй оролцохыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх шатны аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалан, идэвх оролцоог хангаж ажилласан. Тус ажлын хүрээнд 260361 ширхэг мод, бут, сөөг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, 267,000 гаруй гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу 1, 2, 6, 8, 11, 13, 14, 15, 20, 21 дүгээр хорооны 17 байршилд нийт 2805 м.кв талбайд цэцгийн мандал байгуулах, 46341.2 м.кв сул шороон хөрс бүхий талбайг шинээр зүлэгжүүлэх ажлууд тус тус хийгдсэн бөгөөд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 250 гаруй аж ахуйн нэгжүүдэд уриалга хүргүүлж ажилласан.	100%	100	
7	18	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.3. Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос хавдрын эмнэлэг, донтох өвчнийг эмчлэх төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг байгуулах, архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлд зарцуулах;	Архи, тамхины хэрэглээг бууруулах, соён гэгээрүүлэх чиглэлээр Засаг даргын Тамгын газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэс хамтран ерөнхий боловсролын 8 сургуулийн 978 сурагчдад “Архи, тамхины хор хөнөөл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд 18 удаагийн “Архины албадлага болон сайн дурын эмчилгээ” тусгай арга хэмжээгээр архины хамааралтай 301 иргэнийг эмчийн үзлэгт хамруулснаас нэн шаардлагатай 94 иргэнийг албадан, 207 иргэнийг сайн дурын эмчилгээнд, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас зохион байгуулсан “Итгэл”	80%	70	

				төслийн хүрээнд 11 иргэнийг 28 хоногийн сайн дурын эмчилгээнд тус тус хамруулсан. Электрон тамхины хуулийн зохицуулалт байхгүй, өсвөр үеийн хүүхэд, залуучуудын хэрэглээ их байгаа талаар иргэдийн өргөдөл, гомдол ихээр ирсэнтэй холбогдуулан 785 иргэнээс асуулга авч, дүнг үндэслэн дүүргийн Засаг даргын 2022 оны А/176 дугаар захирамжаар 21 нас хүрээгүй хүнд худалдаалах, албан байгууллага дотоод орчиндоо хэрэглэхийг тус тус хориглож, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.			
	19		1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Төрийн болон хувийн хэвшлийн оролцоотойгоор дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт 35 га талбайд 15 байгууламж бүхий "Олон улсын соёлын цэцэрлэгт хүрээлэн" байгуулах төсөл хэрэгжиж байна. Тус ажлын хүрээнд 2022 онд 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 3.47 га талбайд экспо талбай байгуулж, мод, зүлэг шинээр тарьж тохижуулснаас гадна 12 дугаар хороонд 3x3 сагсан бөмбөгийн талбай, 20 дугаар хороо, Лавайн худалдааны төвийн зүүн талд сул шороон хөрс бүхий талбайг тохижуулж, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх ая тухтай орчинг бүрдүүлсэн. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 11 хорооны нутаг дэвсгэрт 16 байршилд тохижилт, ногоон байгууламж, спорт тоглоомын талбай 9, 3x3 сагсан бөмбөгийн талбай 5, хөлбөмбөгийн талбай 2-ыг тус тус байгуулсан. Дүүргийн төсвийн 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2021 оноос дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 10 хорооны 13 байршилд, 2022 онд 7 хорооны 8 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий спорт тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай, амралтын талбайг тус тус бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөдөлгөөнийг	100%	100	

			сайжруулах зориулалт бүхий тусгай тоглоомыг суурилуулсан.				
	20		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Архи согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, хорт зуршлыг сурталчлах, иргэдэд таниулах зорилгоор 6 удаагийн постер бэлтгэн цахим мэдээллийн сайтаар сурталчлан ажилласан. Дүүргийн ИТХ-ын ажлын албатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч, эцэг эхийн төлөөлөлд “Мансууруулах эм, хар тамхины хор уршиг, шалтгаан, хүчин зүйл, эрх зүйн орчин болон урьдчилан сэргийлэх арга зам”, “Шинэ үеийн залуучуудын сонголт архи биш” сэдэвт сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж 117 эцэг эхийн төлөөлөл, сэтгэл зүйч хамрагдсан. Дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэстэй хамтран “Архи, согтууруулах ундааны хор хөнөөл ба гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдөр, 10 дугаар сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулж 25 иргэн хамрагдсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны “Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх” талаар уриалга гаргаж, тогтоол шийдвэрийн хамт хороод болон 1538 иргэн, аж ахуйн нэгжид хүргүүлж, ажилласан.	90%	100	
8	21	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.3.. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, нормативыг нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бусад нөлөөлөх үзүүлэлтийг харгалзан шинэчлэн тогтоох, согтууруулах ундааны импортыг бууруулж, дотоодын үйлдвэрлэлд тавих хяналтыг чангатгах, энэ төрлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх цагийн хуваарийг богинсгож 08.00-24.00 цаг болгох, долоо хоног бүрийн нэг өдрийг архи согтууруулах ундаагаар үйлчлэхгүй, худалдан борлуулахгүй байх, 400 мл хүртэлх жижгээр савалсан архи дэлгүүрүүдээр зарахыг хориглох эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ажиллах цагийн хязгаарыг шинэчлэн тогтоохтой холбогдуулан нийт 587 иргэн аж ахуйн нэгжийг хамруулан цахим санал асуулга, хэлэлцүүлэг зохион байгуулж, дүнг удирдлагад танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаарыг тогтоох тухай” А/832 дугаар захирамжийг архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 821 аж ахуйн нэгжид хүргүүлж, дүүргийн цахим хуудсаар олон нийтэд танилцуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй 530, үйлчлэх	90%	100	

				тусгай зөвшөөрөлтэй 291, нийт 821 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн хүн амын тоог /222470/ хороо тус бүрээр 1000 хүн ам тутамд 4 цэг байхаар судалгааг улирал тутам шинэчлэн гаргаж, ХХААХҮЯ-ны сайдын 2020 оны “Норматив тогтоох тухай” А/272 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			
	22		1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Хүнсний аюулгүй байдал, сургуулийн орчинд хориглосон бүтээгдэхүүний жагсаалтын талаар 2000 ширхэг гарын авлага хэвлүүлэн, Засаг даргын Тамгын газар, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын албатай хамтран хяналт шалгалт зохион байгуулж, 314 ТҮЦ, ил задгай худалдаа эрхлэгчдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хадгалалтын хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүн худалдаалж буй зөрчил шалгалтын 19,4 хувь илэрснийг журмын дагуу устгуулсан. Шалгалтад хамрагдсан нийт худалдаа үйлчилгээний газруудын 11.1 хувь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4-д заасан мэдээллийг бүрэн тусгаагүй зөрчил илрүүлснийг улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/466 дугаар захирамжийн дагуу Иргэдийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, явган хүний зам талбай хаан байршуулсан, стандарт шаардлага хангахгүй 23 түргэн хоолны цэг болон ТҮЦ-ийг нүүлгэн шилжүүлсэн.	100%	100	
9	23	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны гаднах хаяг, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын 35 өрөө, 24 хороодын гаднах хаяг болон дүүргийн Жижиг дунд, үйлдвэрлэлийг дэмжих төв, Албан бус насан туршийн боловсролын төв өрөөнийхөө гаднах хаягийг монгол бичгээр шинэчлэн хийсэн. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч аттестатчиллын шалгалтад хамрагдаж буй 239 аж ахуйн нэгж байгууллагад чиглэл өгч ажилласан. Шалгалтад хамрагдсан 2 аж ахуйн нэгж хаягийн байгууламждаа монгол бичиг оруулсан.	80%	70	

	24		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв 2022 онд монгол бичгийн анхан дунд, шатны 5 удаагийн танхимын сургалтад 193 төрийн албан хаагч, цахим сургалтад 44 иргэнийг хамруулсан. Монгол бичгийн сургалтад ашиглагдах цахим хэрэглэгдэхүүн, бие даан ажиллах дасгал, унших, бичих эх, чиглүүлэгчтэй дасгал зэрэг 6 төрлийн 90 гаруй дасгал даалгаврыг боловсруулж, сургалтын чанар, агуулгыг сайжруулсан. Анхан шатны 16 цагийн сургалтад хамрагдсан 41 суралцагч үр дүнгийн шалгалтаа өгөн дунд шатанд дэвшин суралцаж байна. Сургалтын хүрээнд 2022.05.20-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн албан хаагчдын монгол бичгийн сургалтын үр дүнг тайлагнах, монгол бичгийн олон талт хэрэглээний чадвар, багаар ажиллах чадварыг сайжруулах, хамт олны уур амьсгалд эергээр нөлөөлөхөд зорилгоор “Үндэсний бичиг-бидний бахархал” тэмцээнийг зохион байгуулсан.	80%	70	
Ерөнхийлөгчийн 5 зарлигын 12 заалтын биелэлт				90.4%			
Дөрөв. ҮАБЗ-ийн зөвлөмж							
10	25	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03"	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-тай хамтарч мод, бут, сөөг, цэцэг, зүлэг тарьж, ургуулах, арчилж, хамгаалах, үр, суулгац бэлтгэх чиглэлээр 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр танхимын болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн их сургуультай хамтарч иргэдэд мод тарих, зөв арчилж хамгаалах соёлыг түгээн сурталчлах 41 сургагч багшийг 3 модуль, 15 сэдвийн 20 цагийн багц сургалтад хамруулж, батламж олгосон. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан 1000 сургагч багш бэлтгэх хөтөлбөрт 2 иргэнийг хамруулж, сертификат олгосон. Бэлтгэгдсэн сургагч багш нар аяны туршид мод тарьж байгаа иргэд, аж	100%	100	

				ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв” УТҮГ-тай хамтран 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан “Тарья, арчилъя, усалъя, ургуулья” сэдэвт сургалтад хороодын Засаг дарга бусад албан хаагчдын хамруулсан. “Ногоон хот – Иргэний оролцоо мод тарих аян” мод тарих, арчлах хамгаалах хялбаршуулсан заавар, бүхий 1650 ширхэг гарын авлагыг бэлтгэж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэхийн зэрэгцээ Мод тарих, арчлах талаар видео шторк бэлтгэж дүүрэг, хороодын цахим хуудсаар сурталчилсан.			
ҮАБЗ-ийн 1 зөвлөмжийн 1 заалтын биелэлт				100%			
Тав. Засгийн газрын тогтоол							
11	26	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:</p> <p>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;</p> <p>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;</p> <p>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;</p> <p>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын</p>	Хан-Уул дүүргийн www.khanuul.mn цахим сайтад монгол бичгээр мэдээ, мэдээллийг түгээх цэсийг нээж, үйл ажиллагаанд оруулаад байна. Албан бус-Насан туршийн боловсролын төвөөс Монгол бичгийн анхан, дунд шатны 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, танхимын сургалтад 193 төрийн албан хаагч, цахим сургалтад 44 иргэнийг хамруулсан. Монгол бичгийн сургалтад ашиглагдах цахим хэрэглэгдэхүүн, бие даан ажиллах дасгал, унших, бичих эх, чиглүүлэгчтэй дасгал зэрэг 6 төрлийн 90 гаруй дасгал даалгаврыг боловсруулж, сургалтын чанар, агуулгыг сайжруулсан. Нийслэлийн Боловсролын газраас зохион байгуулсан “Монгол бичиг заах арга зүйн зөвлөмж” сургалтад 78 багш, Боловсролын хэлтсээс зохион байгуулсан “Үндэсний бичиг”-ийн анхан шатны цахим хичээлд төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн 2600 гаруй багш, ажилчид, Монгол бичгийн гүнзгийрүүлсэн болон бийр, уран бичлэгийн сургалтад 14 багш хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл бичиг, уран зохиолын 78 багш, мэргэжлийн 820 багш үндэсний бичгийн программ суулгаж, шивж бичих	70%	70	

			хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	анхан шатны мэдлэгтэй болсон. Сургуулийн өмнөх боловсролын 16 цэцэрлэг монгол бичгийн танхимын сургалтыг зохион байгуулж, 326 багшийг хамруулсан. Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны гаднах хаяг, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын 35 өрөө, 24 хороодын гаднах хаяг болон дүүргийн Жижиг дунд, үйлдвэрлэлийг дэмжих төв, Албан бус насан туршийн боловсролын төв өрөөнийхөө гаднах хаягийг монгол бичгээр шинэчлэн хийсэн.			
12	27	Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах тухай 2022-02-16 Дугаар: 74	3. Тооллогын ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг өрх, аж ахуйн нэгжийг тооллогод бүрэн хамруулж, тооллогын ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хөдөө аж ахуйн тооллого явуулах тухай” А/751, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/332 дугаар захирамжаар дүүргийн тооллогын комиссын бүрэлдэхүүн, тооллого явуулахад шаардагдах нэмэлт зардлыг баталсан. Тооллогыг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр эхлүүлж, 14 хоногийн хугацаанд дүүргийн хэмжээнд 536 нэгжийг тооллогод бүрэн хамруулж, 99.1 хувьтай тоологдсон.	100%	100	
13	28	Журам шинэчлэн батлах тухай 2022-03-09 Дугаар: 97	3. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хүүхэд харах үйлчилгээг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэх болсонтой холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн яамны хамгааллын сайдын 2022 оны А/151 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” -ын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/151 дүгээр захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Төвийн бүс, Нисэх-Яармаг, Био-Өлзийт-Шувуу гэсэн 3 чиглэлийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээдэд заавар, зөвлөмж өгч ажилласан. Тус дүүрэгт хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг 33 төвийн үйл ажиллагаанд Хяналт шалгалт хийснээс 17 төвийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа бөгөөд 362 хүүхэд хамрагдаж байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эргэн нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг	90%	100	

				дэмжих сангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт “Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх” үйл ажиллагаа эрхлэхээр 1 иргэн 10 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.			
14	29	Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар: 118	5. Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр: Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны 250 өрхөд 2.2 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны үрийг олгож, тариалалтыг дэмжин ажилласан. Үүнд: 12 нэр төрлийн 371.2кг хүнсний ногооны үр, 278.450 ширхэг байцааны үрийг олгосон. -Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд зун, хавар, намрын улиралд давхардсан тоогоор 16 удаагийн өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, олон нийтэд сурталчлан 144 тариалан эрхлэгчдийн 939.9тн хүнсний ногооны борлуулалтыг дэмжиж ажилласан. Газар тариалангийн 3 хувийн хүүтэй зээлд хамрагдах хүсэлтэй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, хүлэмж, үр тариа, тос тэжээлийн таримал тариалалтын үйлдвэрлэл эрхэлдэг 477 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. 2022 оны 4 дүгээр сард хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ өрхийн аж ахуй эрхлэгч иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 2022-2023 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг танилцуулах өдөрлөгийг 21 хорооны 400 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулсан. Мөн дүүргийн хэмжээнд төмс, хүнсний ногоо тариалах сонирхолтой 71 иргэний бүртгэл судалгааг гаргаж, Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газарт хүргүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүгийн дэмжлэг олгох төсөл хөтөлбөрт хүнсний ногоо тариалах чиглэлээр 5 иргэнд 45 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Бүлгийн төслийн санхүүгийн буцалтгүй дэмжлэгт 7 иргэнд 12,6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус олгосон.	100%	100	
15	30	Мөнгөн төлбөрийн	2. Цэргийн дүйцүүлэх албыг хаалгах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж,	Цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн иргэдийн нэрийн жагсаалтыг мэдээллийн сангаас	82%	70	

		хэмжээг тогтоох тухай 2022-03-16 Дугаар: 120	мөнгөн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	түүвэрлэн хороо тус бүрээр мэдэгдэх хуудас хүргүүлэн цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгахаар 402 иргэнд мөнгөн төлбөр тогтоосноос 235 иргэн мөнгөн төлбөр төлж, 210 582 161 сая төгрөгийг Нийслэлийн Төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлэн, УИХ-ын 2008 оны 33 дугаар тогтоолын дагуу 98 иргэнийг мөнгөн төлбөр төлөхөөс чөлөөлсөн. Эдийн засгийн боломжоос шалтгаалан 69 иргэн мөнгөн төлбөр төлөх хугацааг хойшлуулан тогтоолгосон.			
16	31	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах ТУХАЙ 2022-04-06	1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан "Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх" богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт "Алсын хараа-2050" сэдэвт цахим сургалтад Засаг даргын Тамгын газрын 20, Засаг даргын дэргэдэх, хэлтэс албадын 19, нийт 39 төрийн албан хаагчийг хамруулж, гэрчилгээ олгосон. Мөн Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимтэй хамтран 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр "Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого" сэдэвт сургалтыг Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын 40 гаруй албан хаагчдад танхимаар зохион байгуулсан.	90%	100	
	32		2. Богино хугацааны сургалтыг 2022 онд зохион байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Тайлант хугацаанд Удирдлагын академитай хамтран "Бодлогын үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь" сэдвээр 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын 40 гаруй албан хаагчдыг хамруулан 1,2 сая төгрөгийн төсөвтэй богино хугацааны захиалгат сургалт зохион байгуулсан. Богино хугацааны захиалгат сургалтад 2023 онд шаардагдах зардлыг төсөвт тусгахаар санал хүргүүлсэн.	100%	100	
	33		3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т,	Албан хаагчдыг сургаж мэргэшүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2 албан хаагчийг төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад хамруулахаар тусгаж, холбогдох зардлыг санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн.	90%	100	

			сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.				
17	34	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай 2022-05-04 Дугаар: 180	3. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хаягжуулалтын үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нэвтэрснээс хойш 845 иргэний газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг шинээр хэвлэж олгосон байна. Системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.	10%	0	
18	35	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар: 187	1. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай: 1.1.Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт;	Дүүргийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 11-11 төвөөс нийт 2133 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс судлагдаж байгаа 70, хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 37, хугацаандаа шийдвэрлэсэн 2026 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 08 хоног 06 цаг 10 минут байна. Засаг даргын Тамгын газарт нийт 367 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс судлагдаж байгаа 18, хугацаандаа шийдвэрлэсэн 349 байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 07 хоног 14 цаг 23 минут байна. Тайлант хугацаанд Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг Тамгын газрын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд 21, Засаг даргын зөвлөлийн хуралд 4, удаа танилцуулж, дэргэдэх хэлтэс албад болон хороодод Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/182, 04/486, 04/1127 болон Засаг даргын 04/266, 04/369, 04/371 дүгээр албан бичгүүдээр тус тус зөвлөмж хүргүүлсэн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөрчлийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн хамт	100%	100	

				Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд Засаг даргын Тамгын газрын 2022 оны 04/502, 04/1102, 04/1637 албан бичгээр 3 удаа тайлагнаж, khanuul.mn сайтад байршуулсан.			
19	36	Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2022-05-11 Дугаар: 192	2. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг салбарын онцлог болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэмэгдүүлж олгох асуудлыг зохицуулахад чиглэсэн арга хэмжээг батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй."	Монгол Улсын Засгийн газраас үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосонтой холбогдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн шатлалыг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны Б/48 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны Б/105 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг 25 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоож, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгосон.	100%	100	
20	37	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар: 203	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны Б/34, Б/54, Б/68 дугаар захирамжаар Засаг даргын 3 орлогчийг үүрэгт ажлаас чөлөөлсөн.	100%	100	
	38		1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2022 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 61,482.7 сая төгрөгийн 26.56 хувийн хэмнэлттэй ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэмнэж болох 6 төрлийн зардлыг хэмнэн нийт төсвийн 23 хувь буюу 2,248.8 сая төгрөгийн хэмнэлтийг хийн ажилласан.	100%	100	
	39		1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт,	Тайлант хугацаанд байгууллага дээрх төлөвлөгдсөн 3 сургалтыг цахимаар зохион байгуулсан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн "7-4-10" цахим сургалтад албан хаагчдыг ажлын байран дээр идэвхтэй хамруулсан. Дүүргийн Засаг даргын дэргэдэх байгууллагын удирдах	100%	100	

			семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;	ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 41 удаа, хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 33 удаа тус тус цахимаар зохион байгуулсан.			
	40		1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/62 дугаар захирамжаар зураг төсвийн 16 ажлын жагсаалтыг баталсан. Батлагдсан зураг төсвийн төсөл арга хэмжээнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон төсөл, арга хэмжээг дүүргийн Засаг даргын 2022 оны А/246, А/362 дугаар захирамжаар өөрчлөн шинэчилж, 19 төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлж батлан хэрэгжүүлсэн.	100%	100	
21	41	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар: 204	1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийслэлийн Засаг даргын А/789 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутгийн захиргааны байгууллага болон ОНӨААТҮГ-ын албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглаж байсан нийслэлийн өмчид бүртгэлтэй 10 суудлын авто тээврийн хэрэгслүүдийг батлагдсан хуваарийн дагуу нийслэлийн Төр захиргааны авто баазад актаар хүлээлгэн өгч, тайланг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 12/1488 дугаар албан бичгээр нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.	100%	100	
	42		9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны Б/87, Б/82 дугаар тушаалаар 2 жолоочийг өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлсөн бөгөөд Б/127, Б/,141, Б/156 дугаар тушаалаар 3 жолоочийг ижил төстэй өөр ажилд шилжүүлэн, нийт 5 жолоочийн орлого, нийгмийн баталгааг бууруулахгүйгээр шийдвэрлэсэн.	100%	100	

			өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.				
22	43	Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-31 Дугаар: 218	1. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх дараахь арга хэмжээг авч, 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг дор дурдсан Засгийн газрын гишүүд, холбогдох төсвийн захирагч нарт тус тус даалгасугай: 1.1. сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн нийт тоо, түүний өсөлтийн хувь, цэцэрлэгийн хүчин чадал, анги, танхимын багтаамж, өрхийн мэдээллийн сан, гэр болон цэцэрлэг хоорондын зай зэргийг харгалзан нийслэлийн цэцэрлэгийн хамран сургах тойргийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тогтоох аргачлал боловсруулж баталсны үндсэн дээр тойргийг шинэчлэн тогтоох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Нийслэлийн Боловсролын газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 09-ний “Хамран сургах тойрог тогтоох тухай” А/82 дугаар тушаал, 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн “Хамран сургах тойрогт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/97 дугаар тушаал, 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн “Хамран сургах тойрогт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/108 дугаар тушаалын хүрээнд төрийн өмчийн 31, төрийн бус 97 цэцэрлэгийг хавсралтаар баталгаажуулсан. Монгол Улсын Засгийн газраас санаачилсан “Хүүхэд бүрийг цэцэрлэгт” хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн бүртгэл 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 26-ны өдрийн хооронд E-Mongolia-аар цахим бүртгэлийг гурван үе шаттай зохион байгуулагдаж 21042 хүүхэд системээр хуваарилагдаж баталгаажсан. 2022-2023 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн төрийн өмчийн 31 цэцэрлэгт-15445 хүүхэд, төрийн бус өмчийн 90 цэцэрлэгт-8908, хүүхэд харах үйлчилгээнд 18 төвд-353 хүүхэд, СӨБ-ын 2-5- настай-24706 хүүхдүүдийг хамруулсан. Мөн Төрийн өмчийн 15 цэцэрлэгт 41 түрээсийн байранд 158 бүлэгт 5430 хүүхдийг хамруулсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/398 дугаар захирамжаар цэцэрлэгийн цахим элсэлттэй холбоотой мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх үүрэг бүхий боловсролын шуурхай багийг байгуулж, 2022 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс шуурхай удирдлагын 88161244, 77530332 дугаарын утсаар иргэдэд мэдээлэл өгч, тойм мэдээг Нийслэлийн Боловсролын газарт тогтмол хүргүүлэн ажилласан.	100%	100	
23	44	Ургац хураалтын бэлтгэл ажлын талаар авах зарим арга	1. Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд гүйцэтгэх зорилгоор их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан, сонсогч, хугацаат цэргийн алба хаагчид болон	Ургац хураалтын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор цагийн ажилд Хөдөө Ах Ахуйн Их сургуулиас 20 оюутныг зуучилж, Төв аймгийн Борнуур суманд 14 хоногийн хугацаатай	100%	100	

		хэмжээний тухай 2022-07-20 Дугаар: 276	иргэдийг сайн дурын үндсэн дээр ургац хураалтын ажилд татан оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	ажиллуулсан. Ургац хураалтын ажлын захиалгын дагуу 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 10 иргэнийг ажиллуулсан. Эко ногоон бүлгийн 30 иргэнийг ургац хураалтын ажилд дэмлэг үзүүлэх зорилгоор Төв аймгийн Батсүмбэр сумын сангийн аж ахуйд 10 хоног тус тус ажилуулсан.			
24	45	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2022-07-27 Дугаар: 279	2. Цэргийн албыг тогтоосон хязгаарт багтаан биеэр дүйцүүлэн хаалгах арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах албанд элсэхээр хүсэлт ирүүлсэн иргэдийг сонгон шалгаруулж, эрүүл мэндийн үзлэгээр оруулж, дүүргийн Засаг даргын 2022 оны А/324 дүгээр захирамжаар 6 иргэнийг элсүүлж, сургалт бэлтгэлийг зохион байгуулахаар 2022-2024 онд цэргийн дүйцүүлэх алба хаалгах гэрээг байгуулан бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн 2022 оны 06 дугаар сарын 17-30-ны өдрийг дуустал, тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг Сүхбаатар дүүргийн Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр ангийн байрлалд 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 02-ныг хүртэл тус тус зохион байгуулж, цэргийн хэргийн болон үүрэг гүйцэтгэх үеийн мэдлэг, дадлагыг олгосон.	100%	100	
25	46	"Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-06-23 Дугаар 2021_173"	3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт, санхүүгийн зохих дэмжлэгийг үзүүлж ажиллахыг аймаг, дүүргийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/481 дүгээр захирамжаар "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс"-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Тус комисс 2022 онд 19 удаа хуралдаж, нийт 711 хүүхдийн асаргаа халамжийн асуудлыг шийдвэрлэсэн. 121 хүүхдэд шинээр асаргаа тогтоож, 13 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 15 хүүхдэд туслах хэрэгсэл олгосон. Комиссын 2022 оны үйл ажиллагааны зардалд шаардагдах 1.0 сая төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төсвөөс шийдвэрлэсэн.	100%	100	
26	47	"Төрийн албаны цалингийн нэгдсэн систем	3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг	Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо" цахим системд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 159 албан хаагч бүртгэлтэй байгаа бөгөөд системд бүртгэлтэй албан хаагчдын мэдээлэлд тухай бүр	100%	100	

		нэвтрүүлэх тухай 2020-05-06 Дугаар 2020_163"	хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.	баяжилт хийж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажилласан.			
27	48	"Төлөвлөгөө батлах тухай 2021-01-20 Дугаар 2021_18"	"2. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай. 2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн жил бүрийн холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай."	Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн 22 сургуулиас 19 сургууль үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж халуун хоол болон бэлэн бүтээгдэхүүнээр 21759 хүүхдийг хамруулан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдад эрүүл, чанартай халуун хоол, хүнсээр үйлчлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын дагуу явуулахад дэмжлэг үзүүлж, 10, 18, 26, 60, 135, 156 дугаар сургуулиудад гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэлд шаардагдах нийт 41,618,160 төгрөгийг "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн санхүүжилтээс шийдвэрлэж, 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн	100%	100	
28	49	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258	1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Тайлант хугацаанд хариуцсан ажилдаа алдаа дутагдал гаргасан 6 албан хаагчид сахилгын арга хэмжээ ногдуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын захирамжаар 4 албан тушаалтанд албан тушаалаас бууруулах, 1 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 1 албан хаагчид 1 сарын цалингийн 20 хувиар бууруулах сахилгын арга хэмжээ тус тус авсан.	100%	100	
	50		1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	Дүүргийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 5130 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал, мэдэгдэл ирснээс 57 буюу 0,26 хувь хугацаа хэтрүүлж, 4942 буюу 96,3 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулж, зөрчлийг бууруулах чиглэлээр 5 арга хэмжээтэй төлөвлөгөө боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 85%-тай хэрэгжээд байна.	100%	100	

			Төлөвлөгөөнд тусгасны дагуу гомдлыг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээний илтгэх хуудсын хамт нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд Засаг даргын Тамгын газрын 2022 оны 04/502, 04/1102, 04/1637 албан бичгээр 3 удаа тайлагнасан.			
51		1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/129 дүгээр захирамжаар батлагдсан бүтцийн дагуу 34 албан тушаалын харьцуулалт хийж, Засаг даргын Тамгын газрын 2022 оны 04/644 дугаар албан бичгээр, мөн дүүргийн Засаг даргын А/527 дугаар захирамжаар батлагдсан бүтцийн дагуу дахин албан тушаалын харьцуулалтыг шинэчлэн боловсруулж, тус тус Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/18, А/87 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг тус тус баталж хэлтэс, албадын уялдаа холбоог сайжруулсан.	90%	100	
52		1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, 44 дүгээр зүйлийн холбогдох заалтыг үндэслэн нийт 27 шийдвэр гаргаж, албан хаагчдыг шатлан дэвшүүлэн болон шилжүүлэн томилсон. Ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагч болон байгууллагын удирдлагатай тохиролцож 5 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан.	90%	100	
53		1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Жилийн эцсийн байдлаар ажлын зайлшгүй шаардлагаар Хан-Уул дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулах ажилд 2 гэрээт ажилтан 2 сарын хугацаатай, байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтэд бэлтгэх ажлын хүрээнд 5000 гаруй хадгаламжийн нэгжийг архивын стандартад нийцүүлэх ажилд 1 гэрээт ажилтан 3 сарын хугацаатай тус тус томилон ажиллуулсан. Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4 дэх заалтыг үндэслэн жирэмсний болон амаржсны амралттай байгаа 7, урт хугацааны чөлөө авсан 1 албан хаагчийн сул орон тоо гарсныг Төрийн албаны тухай хуульд	90%	100	

			заасны дагуу төрийн албаны нөөцөд бүртгэлтэй 2 иргэнийг томилсон.			
54		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Дүүргийн Засаг даргын 2022 оны А/245 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн төрийн байгууллагын нийт албан хаагчдад дараах зүйлийг үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллахыг даалгаж, нутгийн захиргааны 98 байгууллагад хүргүүлсэн. Үүнд; а/ төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг сахиж ажиллах, б/ажлын цагаар удирдлагын зөвшөөрөлгүйгээр ажлын байраа орхиж явахгүй байх, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, в/ албан хаагчид ажлын байранд тамхи татах, согтууруулах ундаа хадгалах болон хэрэглэхийг хатуу цээрлэх, Мөн зөрчил гаргасан албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосон. Энэ онд Ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэсэн 1 албан хаагчид Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 1 сарын цалинг 20 хувиар бууруулах сахилгын арга хэмжээ авсан.	90%	100	
55		1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/35 дугаар тушаалын хавсралтаар “Захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын дагаж мөрдөх харилцаа хандлагын нийтлэг журам”-ыг мөрдлөг болгон ажилласан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйтэй холбоотой нийт 7 өргөдөл ирүүлснээс 5 албан хаагчтай холбоотой асуудлыг байгууллагын Ёс зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор дээрх 5 албан хаагчид сануулах хариуцлага хүлээлгэсэн бөгөөд тус дүүргийн 10 дугаар хорооны нийгмийн ажилтанд ЗДТГ-ын даргын 2022 оны Б/55 тушаалаар албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл, 4 дүгээр хорооны хэсгийн ахлагчид урамшууллын 20 хувийг хасах шийдвэр гаргаж тус тус хариуцлага тооцсон.	90%	100	

	56		<p>1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, байгууллага дотор дагаж мөрдөх бусад журмын хэрэгжилтийг ханган зөрчил илэрсэн тохиолдолд Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг баримтлан ажилласан. Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 4.6.2-т “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим болох жендэрийн тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, төрийн хариуцлагын зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах” гэж тусгасан. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажлын байрны дарамт болон хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх хандлагыг төлөвшүүлэх сэдэвт сургалтыг Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимтэй хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтад Засаг даргын Тамгын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан болон хорооны Засаг дарга нар, нийт 51 албан тушаалтныг хамруулсан.</p>	90%	100	
	57		<p>3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>Байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн албаны соёл, дэг журмыг чангатгах, ажлын цаг ашиглалтыг сайжруулж хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд онцгой анхаарч, хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга болон хорооны Засаг дарга, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгон дүүргийн Засаг даргын 2022 оны А/245 дугаар захирамжийг батлуулж, Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/646 дугаартай албан бичгээр 98 байгууллагад хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаас албан хаагчдын ажлын цаг ашиглалтад онцгой анхаарч, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэл, хүлээгдэлгүй түргэн шуурхай хүргэх</p>	90%	100	

				үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд тус үүрэг даалгаврыг Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/1880 дугаар албан бичгээр хороодод хүргүүлсэн. Засаг даргын Тамгын газар болон хорооны албан хаагчдын цаг бүртгэлийг тогтмол хөтөлж, гэнэтийн шалгалт зохион байгуулан төрийн албаны сахилга, дэг журмыг чанд сахин ажиллахад хяналт тавин ажилласан.			
Засгийн газрын 18 тогтоолын 32 заалтын биелэлт					92.5%		
Зургаа. ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
29	58	2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн тэмдэглэл 2022-02-16 Дугаар: 11	2. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав" гэжээ.	Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй хийх гэрээ, батламжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахимжуулсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: 1. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1675 иргэн, аж ахуйн нэгжийн судалгаа мэдээллийг Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газарт хүргүүлсэн. 2. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд цахим бүртгэлийн системийг танилцуулах сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран 5 удаа танхимаар зохион байгуулж 248, цахимаар 4 удаагийн сургалт зохион байгуулж нийт 566 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж, үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системд бүртгүүлэх гарын авлага бэлтгэж нийт давхардсан тоогоор 1884 иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 3. Цахим бүртгэлийн системд 2022 онд 1018 иргэн, аж ахуйн нэгж хүсэлт илгээснээс шийдвэрлэлт 519 буюу 50.9%-тай байна. Мөн Е-монголиа төрийн үйлчилгээний цахим порталаар гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах, шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэхээр 364 иргэн хандан улсын бүртгэлийн үйлчилгээг цахимаар авсан. Төлбөр төлөх "Гэрэгэ киоск" цахим машиныг 21	90%	100	

				хороонд байршуулан төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна.			
30	59	2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн тэмдэглэл 2022-05-11 Дугаар: 28	3. “Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимчүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, үр дүнтэй ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.” гэжээ.	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын 2022 оны төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд 12 ажил тусган үе шаттай хэрэгжүүлсэн бөгөөд тухайлбал тус дүүрэгт хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тайлагналтыг чанаржуулах ажлын хүрээнд: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд, болон хэрэгжүүлэх арга хэмжээг дүүргийн хэмжээнд бодлогын бусад баримт бичигтэй хэрхэн уялдуулж, төлөвлөн хэрэгжүүлэх, болон Бодлогын үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тодорхойлох нь сэдвээр Удирдлагын академитай хамтран 2022 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд тус тус холбогдох албан тушаалтнуудыг хамруулан сургалт зохион байгуулсан. Мөн дүүргийн Засаг даргын харьяа байгууллагын үйл ажиллагаа, Засгийн газар, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль, тогтоомж, шийдвэрийн эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүн тайланг холбогдох албан тушаалтанд танилцуулж, дүгнэлт, зөвлөмжийг дүүргийн Засаг даргын 2022 оны 06/344 тоот албан бичгээр харьяа 31 байгууллагад хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж байна.	90%	100	
31	60	"2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2022-03-23	IX.11. . “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 370 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав.	Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор байгуулагдсан Хан-Уул дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хохроо багуулагдан, 2022 онд 4 удаа хуралдаж, 9 ажилтны хөдөлмөрийн эрхийн маргааныг хянан	90%	100	

		Дугаар 2022_17"	Үүнтэй холбогдуулан салбарын болон аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	шийдвэрлэж, шийдвэрийг маргалдагч талуудад хүргүүлсэн.			
	61		IX.15. . Нийслэлийн хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан бэлтгэсэн махыг худалдаалахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн махыг 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн татварын цахим системд баталгаажсан баримтад үндэслэн худалдан борлуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Татварын ерөнхий газар (Б.Заяабал) нарт;	Хүн амын хаврын хэрэгцээний махны хүртээмж, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр нөөцийн махны жижиглэн худалдааг 48 хүнсний дэлгүүр, 12 сүлжээ дэлгүүрээр 135.6 тонн, өргөтгөсөн худалдааг давхардсан тоогоор 39 байршилд зохион байгуулж 323.5 тонн, нийт дүүргийн хэмжээнд 459.1 тонн нөөцийн мах худалдан борлуулж, цахим төлбөрийн баримтыг олгож ажилласан.	100%	100	
32	62	"2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16"	ХҮИИ.17.1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааны явцын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 2 дугаар албан даалгавраар өгөгдсөн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарласан байх үүргийн хэрэгжилт Улаанбаатар хотод хэрэгжих төсөл, арга	Хан-Уул дүүрэгт улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээ байхгүй болно. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/133 дугаар захирамжаар эрх шилжиж ирсэн, тус дүүргийн 4 дүгээр хороонд баригдах 240 ортой цэцэрлэгийн барилгын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан.	100%	100	

			хэмжээний худалдан авах ажиллагааны хувьд хангалтгүй байгаа тул уг асуудалд анхаарал хандуулах, эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазарт даалгав;				
	63		ХҮИИ.17.2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав;	Тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 36 гэрээ, нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 5 гэрээ, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 35 гэрээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих 4 гэрээ нийт 80 гэрээг төрийн худалдан авах ажиллагааны цахим www.tender.gov.mn болон https://report.ub-procurement.mn/ тогтмол оруулан ажиллаж байна. Гэрээ байгуулах эрх олгосон 28 төсөл арга хэмжээ байна.	85%	70	
	64		ХҮИИ.17.3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав;	Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж, зураг төсвөө батлуулсан 14 төсөл арга хэмжээ, Нийслэлийн 2023 оны төсвийн төсөлд тусгах техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж, зураг төсвөө батлуулсан 25 төсөл арга хэмжээний жагсаалтыг тус тус нэгтгэн боловсруулж, дүүргийн Засаг даргын 2022 оны 06/295 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.	100%	100	
33	65	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	XIY.7.1. Инфляцын нөхцөл байдал, үнийн өсөлтийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтанд даалгав: 1. Нөөцийн махыг хэрэглэгчдэд хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах арга хэмжээг авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Хүн амын хаврын хэрэгцээний махны хүртээмж, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр нөөцийн махны жижиглэн худалдааг 48 хүнсний дэлгүүр, 12 сүлжээ дэлгүүрээр 135.6 тонн, өргөтгөсөн худалдааг давхардсан тоогоор 39 байршилд 323.5 тонн, нийт дүүргийн хэмжээнд 459.1 тонн нөөцийн мах худалдан борлуулж, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажилласан.	100%	100	

	66		<p>XIY.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Төмс, хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээг 12 иргэн ААН-ийн 146.3тн хүнсний ногоонд олгосон бөгөөд мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажилласан.</p>	100%	100	
34	67	<p>2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл 2022-02-23 Дугаар 2022_12</p>	<p>X.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.</p>	<p>Дүүргийн хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 11-11 төвөөс нийт 2133 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснээс 1,7 хувийг хугацаа хэтрүүлж, 94,9 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд тайлант хугацаанд 1 асуудлаар удаа дараа гомдол гаргаагүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланд улирал тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүн мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд 4, Тамгын газрын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд 21, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 2 удаа тус тус танилцуулсан. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад удаа дараа зөрчил гаргасан Засаг даргын дэргэдэх 12 хэлтэс, албад болон хороодод Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04/182, 04/486, 04/1127 болон Засаг даргын 04/266, 04/369, 04/371 дүгээр албан бичгүүдээр тус тус зөвлөмж хүргүүлж ажилласан.</p>	100%	100	
35	68	<p>2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2022-08-10 Дугаар 2022_40</p>	<p>2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Намрын ногоон өдрүүд- Үндэсний үйлдвэрлэл 2022” нэгдсэн арга хэмжээг Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, холбогдох зардлыг хамтран шийдвэрлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд</p>	<p>Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2022” арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулан дүүргийн 14 газар тариалан эрхлэгчид бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан оролцож, 19.9тн төмс, хүнсний ногоог худалдан борлуулсан. Дүүргээс төсөв гараагүй болно.</p>	100%	100	

			Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгов.			
	69		3. Орон нутгийн хүнсний ногоочдын борлуулалтыг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах цэг, талбай гаргаж, нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт даалгав" гэжээ.	Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн худалдааг давхардсан тоогоор нийт 10 байршилд зохион байгуулж, 130 газар тариалан эрхлэгч 920 тн төмс, хүнсний ногоо худалдан борлуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Мэргэжлийн хяналтын хэлтэс, Татварын хэлтэс хамтран хяналт тавьж, зохион байгуулалтаар хангаж ажилласан.	100%	100
36	70	2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	2.4. Зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актад хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, 2022 оны 10 дугаар сард багтаан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад" гэжээ	Хан-Уул дүүргийн Засаг даргаас зөвшөөрлийн харилцааг зохицуулсан хэм, хэмжээний акт гараагүй байна. Бусад холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон дүүргийн Засаг даргын 15 захирамжийн холбогдох 30 заалт Зөвшөөрлийн тухай хуульд нийцсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, илтгэх хуудсыг Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 06/1776 тоот албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	100%	100
ЗГ-ын 8 хуралдааны тэмдэглэлийн 13 заалтын биелэлт					96.5%	
Долоо. МУ-ын Ерөнхий сайдын албан даалгавар						
37	71	2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр 03 дугаар албан даалгавар 2022-03-04 Дугаар: 03	4. Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нийтэлж байхыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатын Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.	Байгууллагын ил тод байдлын мэдээ, мэдээллийг дүүргийн www.khanuul.mn цахим вэб сайтад тухай бүр нийтэлж, иргэдэд түгээн ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар байгууллагын ил тод байдал, хууль тогтоомж, нийслэл, дүүргийн шийдвэр зэрэг үйл ажиллагааны нийт 2852 мэдээллийг нийтэлж, англи танилцуулгатай вэб сайтыг шинээр нээн ашиглалтад оруулсан.	100%	100
МУ-ын Ерөнхий сайдын 1 албан даалгаврын 1 заалтын биелэлт					100%	
Найм. НИТХ-ын тогтоол						
38	72	Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн	2. Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарын өөрчлөлтөд хамрагдсан мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх болон бусад холбогдох арга хэмжээг 2019 оны III	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 21/06 дугаар тогтоолоор мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох хил хязгаарыг шинэчлэн баталж, дүүргийн 12 дугаар хорооны Малчин, Таван толгой, Өлийн ам,	100%	

		хил хязгаарыг шинэчлэн батлах тухай 2019.01.28 Дугаар: 21/06	улиралд багтааж зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан/-д даалгасугай.	Цоохор, Цагаан эрэг, 13, 14 дүгээр хороонд мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрч, бусад хэсэгт хориглосон. 2018-2022 онд дүүргийн хэмжээнд 200 өрхийн 5000 гаруй малыг зөвшөөрсөн бүс нутагт нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны А/499 дүгээр захирамжаар мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хяналт тавих байнгын эргүүл ажиллуулж, хориглосон бүсэд орж ирсэн малыг тууж хашаалан, малын эздийг олж тогтоон, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох ажлыг зохион байгуулсан. Үүнд: Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд 2022 онд хариулгагүйгээр бэлчээсэн давхардсан тоогоор нийт 6294 мал орж ирснээс 3740 малыг хориглосон бүсээс тууж гарган, 2554 малыг хашаалан, 75 иргэнд Мэргэжлийн хяналтын хэлтэс, Цагдаагийн газраас Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 3.75 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус авсан.			
39	73	Журам батлах тухай 2019.04.26 Дугаар: 24/17	1.“Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журам”-ыг хавсралтаар баталсугай. 2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжаар стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгаж, газар чөлөөлөх байршлыг баталсан. Тус захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2022 оны А/211 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, дүүргийн нутаг дэвсгэрт 19 байршлын 1361м хашааг чөлөөлөхөөр төлөвлөсний дагуу зөрчлийг бүрэн арилгаж орц гарцыг нээж хөдөлгөөний нэвтрэх чадамжийг дээшлүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжаар Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 17 байршлын 183 гараашийн газрыг албадан чөлөөлөхөөр төлөвлөсний дагуу 183 гараашийг бүрэн чөлөөлсөн. Төлөвлөгөөнд тусгагдаагүй тус дүүргийн 2 дугаар хороонд 3 гарааш, 3 дугаар хороонд 4 тоосгон гарааш нийт 190 гараашийг чөлөөлсөн.	100%		

40	74	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020.12.04 Дугаар: 02/09	2.“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг батлагдсантай холбогдуулан нийслэл, дүүрэг, хороо, харьяа нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг үндсэн чиглэлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх түүний үр дүн, биелэлтийг гаргаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны төлөвлөгөөний 3 бүлэг, 3 зорилт, 3 арга хэмжээ 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 57 хувьтай хэрэгжсэн ба 1 арга хэмжээ 30 хувьтай үнэлэгдсэн байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 06/1455 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	90%		
41	75	“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 2020.12.04 Дугаар: 02/10	3.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.	“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 22 зорилт, 46 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 91 хувьтай хэрэгжсэн. Биелэлтийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 06/2058 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	100%		
42	76	“Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” батлах тухай 2021.12.03 Дугаар: 11/31	Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох санхүүжилтийг Нийслэлийн 2022 оны төсөвт тусгах, түүний хэрэгжилт, үр дүнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.	Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнөөс тус дүүрэг хамтран хэрэгжүүлэх 6 бүлэг, 59 зорилт, 60 арга хэмжээний хэрэгжилт 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 57 хувьтай хэрэгжсэн. Биелэлтийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 06/1455 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.	90%		
43	77	Журам шинэчлэн батлах тухай 2022.05.30 Дугаар: 37	3. Тогтоол батлагдсантай холбогдон гарах зардлыг нийслэлийн жил бүрийн төсөвт тусгуулан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д даалгасугай.	НИТХ-ын 2022 оны 37 дугаар тогтоолыг дүүргийн 24 хороодод Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 04/1095 дугаар албан бичгээр хүргүүлэн, “Хэсгийн ахлагчийн ажиллах журам”-ын дагуу хөлсөөр ажиллах гэрээг нийт 205 хэсгийн ахлагчтай шинэчлэн байгуулж, цалин, урамшууллыг 2023 оны төсөвт тусгах саналыг хүргүүлсэн.	100%		

НИТХ-ын 6 тогтоолын 6 заалтын биелэлт				96.6%			
Ес. НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол							
44	78	Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2018.07.09 №119	1.3.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүр өмчийн харьяалалд үл хамааран орчны тохижилт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг баримтлан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж шаардах иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх	Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 280 ширхэг гарын авлага, зөвлөмж, видео хичээлийг ерөнхий боловсролын 48 сургуульд хүргүүлж, JICA Олон улсын байгууллагаас ерөнхий боловсролын 26, 34, 75 дугаар сургуулийн “Дэмжлэгийн баг”-т 15.0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, сургуулийн 1, 2 дугаар давхрын хонгил, ариун цэврийн өрөөг тохижуулж, 75 дугаар сургуулийн дотоод орчинд тактель замыг байрлуулсан. Дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төв тусгай хэрэгцээт хүүхдийн хэрэглэгдэхүүнтэй өрөөг ашиглалтад оруулж, сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Тэгш суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай ерөнхий боловсролын сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 10, налуу замтай 38 сургууль байна. 2022-2023 оны хичээлийн жилд 510 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна.	90%		
	79		1.3.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, амрах эрхийг хангах чиглэлээр хууль тогтоомж, дүрэм журмыг биелүүлэх	Хариуцсан нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 тусгай арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцсон. Мөн хороодын Засаг дарга, хамтарсан багийн гишүүдтэй хамтарсан зөвлөгөөнийг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж 9 хорооны 65 иргэнийг хамруулсан байна. Хариуцсан нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хүүхэд хамгаалал”, “Илрүүлэлт 2022”, “Зөвийг зөвлөө”, “Өөрчлөлтийг өөрөөсөө”, “хүндлэлээр хүмүүжье”,	100%		

				“Архины албадан эмчилгээ”, “Сайн дурын эмчилгээ” зэрэг нийт ерөнхий 8, тусгай 14 арга хэмжээ зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар архины албадан эмчилгээ 74, сайн дурын эмчилгээнд 168 иргэнийг хамруулсан			
80		1.3.3. Гэмт хэрэг, зөрчил дутагдал, осол эндэгдэл гарсан тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагад яаралтай мэдээлэх, зөрчлийг арилгуулах чиглэлээр харилцан шаардлага тавих;		Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, бууруулах, урьдчилан сэргийлэх “Мэдэгдэл-Хяналт шалгалт” арга хэмжээг зохион байгуулж сууц өмчлөгчдийн холбоо, худалдаа үйлчилгээний газрууд, Их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, шатахуун түгээх станц, гэрээт харуул хамгаалалтын алба, барьцаалдан зээлдүүлэх газар нийт 749 аж ахуйн нэгж, байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг нэн даруй цагдаагийн байгууллагад мэдэгдэх талаар мэдэгдэл хүргүүлж биелэлт үр, дүнг тооцон ажилласан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 4104 чиглэлд 8748 алба хаагч эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж 651 аж ахуйн нэгж, баар, караоке, цахим тоглоомын газар, архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 8 нэрийн дэлгүүр, ТҮЦ зэргийг шалгаж, зөрчил гаргасан 7311 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 62,905,000 төгрөгийн торгууль оногдуулж ажилласан.	100%		
81		1.3.4. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих, тоглож наадах орчин нөхцөлийн аюулгүй байдалд онцгой анхаарч, орон байр, сургууль цэцэрлэг, нийтийн эзэмшлийн зам талбайн стандартыг хангуулах ажлыг зохион байгуулах		Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 3, 11, 15, 19, 21 дүгээр хорооны 5 байршилд ногоон байгууламж, амралтын талбай, тоглоомын талбай бүхий тохижилт, 2 дугаар хорооны 2 байршилд /2 дугаар хороо, 65 дугаар цэцэрлэгийн баруун тал болон 29, 33 дугаар байрны дунд/ авто зогсоол, дугуйн зам, явган хүний зам, чийрэгжүүлэлтийн талбай, ногоон байгууламж бүхий тохижилт, 2, 16 дугаар хорооны 2 байршилд тоглоомын талбайн тохижилт, 1, 13, 21 дүгээр хорооны 5 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбай байгуулах, 34, 52 дугаар сургуулийн гадна талбайд олон улсын стандартад нийцсэн 2 хөлбөмбөгийн талбай байгуулах ажил хэрэгжсэн. Дүүргийн 2021 оны 1.1	100%		

			<p>тэрбум төгрөгийн хөрөнгөөр он дамжин хэрэгжиж буй тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбайг нэмэгдүүлэх 3 багц төсөл арга хэмжээний хүрээнд 1, 2, 3, 12, 15, 16, 18, 19, 20, 21 дүгээр хорооны 13 байршилд тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай /гүйлтийн замтай/, чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмж суурилуулан тохижуулах ажлыг хэрэгжүүлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 2, 11, 12, 16, 17, 20 дугаар хорооны 7 байршилд тохижилт, ногоон байгууламж бүхий тоглоомын талбай, амралтын талбай, спорт талбайн тохижилтын ажлыг шинээр, 1 дүгээр хороо 14, 15 дугаар байрны тоглоомын талбай, бичил цэцэрлэгийг бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хөдөлгөөнийг сайжруулах зориулалт бүхий тусгай тоглоомыг суурилуулсан. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамжийн дагуу “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ 1, 2, 5, 12, 14 дүгээр хорооны 11 байршилд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн эвдрэлтэй тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбайг засварлах, орчны аюулгүй байдал, чанар, стандартыг хангуулах арга хэмжээ авч ажилласан.</p>			
82		<p>1.4.1 Иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, хэв журмын зөрчил, болзошгүй аюул, осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах уриалах;</p>	<p>2022 онд гудамж талбай, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр “Сар шинэ-2022”, “Дахин сэрэмжлэе-Дахин шалгая-3”, “Зөвийг Зөвлөө”, “Хүүхэд хамгаалал”, “Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлье 1,2”, “Байгалиа хамгаалъя”, “Аажуу явбал аяндаа хүрнэдээ”, “Хичээл эхэллээ” зэрэг ерөнхий 8, “Хар тамхигүй дүүрэг”, “Халаас - 21”, “Тэнэмэл”, “Албадан эмчилгээ”, “Мэдэгдэл – Хяналт шалгалт”, “Уул”, “Ломбард”, “Машины эд анги”, “Хүүхэд хамгаалал”, “Нэгдүгээрт хүүхэд”, “Хичээл эхэллээ”, “Хүүхдийн эрх”, Зөвийг зөвлөө” зэрэг 7 ерөнхий, “Өөрчлөлтийг-Өөрөөсөө”, “Хүндлэлээр - хүмүүжье”, “Хүүхэд-Бидний ирээдүй”, “Тэнэмэл”, “Архины албадан эмчилгээ”, “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлье”, зэрэг 6 тусгай, нийт 13 арга хэмжээ, “Хар тамхигүй дүүрэг”, “Электрон тамхины хор</p>	100%		

				нөлөө", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Үе тэнгийн гадуурхалт", "Хүүхэд хамгаалал" зэрэг нийт 34 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцсон. Хөдөлмөр нийгмийн хамгаалалын яам, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран хэрэгжүүлж буй "Хүүхэд хамгаалагч" төслийн хүрээнд дүүргийн Цагдаагийн газрын хариуцсан нутаг дэвсгэрт нийт 29 иргэнтэй гэрээ байгуулж хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 526 хүүхдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан			
45	83	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2018.11.14 Дугаар 165	1.Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас 2018 оны 6,8,10 дугаар сард Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хийсэн дотоод, гадаад орчны аюулгүй байдал, эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын явцын дүнг үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт ҮҮРЭГ ЧИГЛЭЛ БОЛГОХ нь 1.1 Нийслэлийн хэмжээнд өмчийн хэлбэр үл харгалзан сургууль, цэцэрлэгийн дотоод, гадаад орчны аюулгүй байдал, эрсдэлд хяналт тавих Ажлын хэсэг байгуулж, үнэлгээ өгөх ажлыг улирал бүр зохион байгуулах;	Нийслэлийн Боловсролын газрын даргын "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын орчны эрсдэлийн үнэлгээ хийх" удирдамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/153 дугаар захирамжийн хүрээнд "Сургууль, цэцэрлэгийн орчны гадна талбайн тохижилт, аюулгүй байдал, ашиглалтыг шалгах хуудас"-аар төрийн болон төрийн бус өмчийн 48 сургууль, 117 цэцэрлэгийн гадна орчны эрсдэлийн үнэлгээг 2022 оны 03 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан. Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан "Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавигдах нийтлэг шаардлага"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны А/674 дүгээр захирамжаар хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 онд 2 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан. "Монголын Мэргэшсэн Өдөр өнжүүлэхийн холбоо" ТББ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй өдөр өнжүүлэх төвүүдтэй хариуцлагын гэрээ байгуулсан.	90%		
	84		1.2 Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг тогтоож, тэдний эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй асуудлаар нутаг	"Хяналт"-1, 2 тусгай арга хэмжээг 2022 оны 4, 6 дугаар саруудад зохион байгуулж дүүргийн ГХУСАЗСЗ, хороодын Засаг дарга, хамтарсан багийн гишүүдийг оролцуулсан зөвлөгөөнийг	100%		

			дэвсгэрийн хэмжээнд тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж, хүүхэд бүрийг эрүүл, аюулгүй орчинд суралцах боломжийг бүрдүүлж ажиллах;	2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, 7 хоногийн хугацаанд ирсэн гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй нийт 55 дуудлага мэдээллээс удаа дараа дуудлага өгсөн 7 дуудлагыг хамтарсан багаар шийдвэрлэх талаар албан бичиг хүргүүлж, нөхцөл байдлын үнэлгээ хийж 2 иргэнд нэг бүрчилсэн хяналтын хувийн хэрэг нээж хяналт тавьж ажилласан. Дуудлага мэдээллийн дагуу амиа хорлох, үхмээр санагддаг гэх 15 хүүхэдтэй нэг бүрчилсэн арга хэмжээ зохион байгуулж, сэтгэл зүйн болон зургаар тестлэх аргаар хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тогтоож, эцэг эхтэй нь уулзаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийж, “Уучлалын захиа” нөлөөллийн арга хэмжээг 2022 оны 02 сарын 16-ны өдөр зохион байгуулснаар эцэг, эх хүүхдүүд хоорондоо ойлголцсон эерэг үр дүн гарсан. Сургууль орчмын аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 32, 115, 130 дугаар сургуулийн орчимд авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хурд хэмжигч болон тусгай дуут дохио суурилуулах ажил хэрэгжсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Улаанбаатар зам засвар, арчлалт” ОНӨААТҮГ-тай хамтарч 7, 26, 114, 130 дугаар сургуулийн орчмын авто зам дагуу хурд сааруулагч, явган зорчигчийн гарцын тэмдэг, тэмдэглэгээг /172,8 м.кв талбай/ стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.			
НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 7 заалтын биелэлт				97.1%			
Арав. НИТХ-ын тэмдэглэл							
46	85	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хотын хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, чиглэлээр 2016-2020 онд	8. Мод тарьж, ургуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах журам” боловсруулан батлуулах, нийслэл, дүүргийн ногоон байгууламжийг арчлах зардлыг жил бүр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах	Өөрийн хөрөнгөөр тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журмын төсөлд холбогдох саналыг тусгаж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд мод үржүүлгийн газар байгуулах, ойжуулалт, ойн зурвас байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах чиглэлээр ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төсөл арга	90%		

		хийсэн ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хэлэлцээд 2021-03-25 №04	хэмжээнүүдэд нийт 1,179,400,000 төгрөгийн хөрөнгийг дүүргийн төсөвт тусган ажилласан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 10 га талбайд мод үржүүлгийн газар байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил хэрэгжиж байна. Тус техник эдийн засгийн үндэслэлийг үндэслэн мод үржүүлгийн газар байгуулахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, өвлийн хүлэмж шинээр барих, 10 га талбайд усалгааны систем угсрах ажлын зардлыг 2023 оны төсөвт тусгахаар тооцоо судалгаа хийгдэж байна.			
НИТХ-ын 1 тэмдэглэлийн 1 заалтын биелэлт				90%		
НИЙТ 46 ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 85 ЗААЛТЫН БИЕЛЭЛТ				92.6%		

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.САРАНГУА

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Б.АРИУНАА